



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



АЗИЙН ХӨГЖЛИЙН
БАНК



ТОГТВОРТОЙ АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР БОАЖЯ-С ХЭРЭГЖҮҮЛЖ
БУЙ ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ
МОН(3787/3788)АЗ: ХАТГАЛ, ХАНХ, ДАДАЛ СУМДЫН ХОГ ХАЯГДЛЫН
БАЙГУУЛАМЖЫН БАРИЛГЫН АЖИЛ**

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ
“ХЭМЖИЛЗҮЙ” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАЖ
БУЙ ХАТГАЛ ТОСГОНЫ ХОГ ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖ
ТӨСЛИЙН БОМТ-НЫ 2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ: “ХЭМЖИЛЗҮЙ” ХХК
РЕГИСТР: 5061504**

Улаанбаатар хот

2023 он

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР БОАЖЯ-С ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ МОН(3787/3788)АЗ:
ХАТГАЛ, ХАНХ, ДАДАЛ СУМДЫН ХОГ ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖЫН БАРИЛГЫН
АЖИЛ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ “ХЭМЖИЛЗҮЙ” ХХК-
НИЙ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ХАТГАЛ ТОСГОНЫ ХОГ
ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖ ТӨСЛИЙН БОМТ-НЫ 2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ: “ХЭМЖИЛЗҮЙ” ХХК
РЕГИСТР: 5061504

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

“ХЭМЖИЛЗҮЙ” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Б.МӨНХЗУЛ

“ХЭМЖИЛЗҮЙ” ХХК-НИЙ БОХЭ-Н АЖИЛТАН:

Ч.ДАВААСҮРЭН

Улаанбаатар хот

2023 он

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АГУУЛГА

- ОРШИЛ
- ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ
ЗОРИЛТ
- СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
- НЭГДСЭН ДҮН
- ХАВСРАЛТ

ОРШИЛ

“Хэмжилзүй” ХХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр БОАЖЯ-с хэрэгжүүлж буй Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутагт хэрэгжүүлж буй Хатгал тосгоны хог хаягдлын байгууламжын барилгын ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байгаа юм. Тус төслийн БОННУ-ний тайланг 2021 онд байгаль орчны үнэлгээний мэргэжлийн “Газар дэлхий” ХХК хийж гүйцэтгэн, БОАЖЯ-аар батлуулсан болно. Ийнхүү батлагдсан БОННУ болон 2023 оны үйл ажиллагааны төлөвлөлт зэргийг үндэслэн төслийн гүйцэтгэгч нь 2023 оны БОМТ-гөө БОАЖЯ-аар батлуулан, төлөвлөгөөний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаа.

Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд “Хэмжилзүй” ХХК дараах үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Үүнд:

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учирах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах;
- Компанийн удирдлагууд, орон нутгийн иргэд болон хорооны удирдлагатай байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, эргэх холбоо бүхий ажил хэрэгч харилцааг буй болгох;
- “Хэмжилзүй” ХХК өөрийн үйл ажиллагаа болоод төслийн цар хүрээ, нөхцөл байдал хоорондын бодит уялдаа холбоог хангах үүднээс үйл ажиллагааны тогтолцоонд тодорхой хугацаанд хяналт тавих.

2023 онд БОАЖЯ-аар батлуулсан БОМТ-ний болон бусад нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудаа энэхүү тайлангаар тайлагнаж байна.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Хатгал тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах

Төслийн дугаар: 2018/Б53

Төслийн зорилго: Тухайн төслийн гол зорилго нь Хатгал тосгоны хог хаягдлын менежментийн сайжруулах, хууль, журам, стандартын шаардлагыг хангасан хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгууламж, бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах, одоо байгаа хогийн цэгийг булшилж, нөхөн сэргээх зэрэг болно.

Төслийн ач холбогдол: Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад хэрэгжүүлж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)”-ийн “Хөвсгөл дэд төсөл”-ийн хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт орших Хатгал тосгоны одоо байгаа төвлөрсөн хогийн цэгийг дарж булшлах бөгөөд шинээр ландфилл байгууламж бүхий 2 дугаар зэрэглэлийн төвлөрсөн хогийн цэг байгуулна. Мөн тус төвлөрсөн хогийн цэгтэй хамтатган бохир ус цэвэрлэх байгууламж байгуулна. Ингэснээр Хөвсгөл нуурын хатуу болон шингэн хаягдлыг зөв зайлуулж, булшлах асуудлыг шийдэх юм.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Хэмжилзүй” ХХК

Улсын бүртгэлийн дугаар – 9011020053

Регистрийн дугаар - 5061504

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
7-р хороолол, Алтайн 281-309 тоот

Утас: 95398462, 88076479

1.1 Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт

Төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд

“Хатгал тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төсөл”-ийн хүрээнд шинээр ланфилл байгууламж болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулна. Одоо байгаа хогийн төвлөрсөн цэгийн талбайг булшилж, нөхөн сэргээхээр төлөвлөсөн байна.

Хог хаягдлын төвлөрсөн цэг

Шинээр байгуулах хог хаягдлын төвлөрсөн цэгийг Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан ангиллаар “2 дугаар зэрэглэлийн төвлөрсөн цэг” байхаар төлөвлөсөн байна. Тус хог хаягдлын төвлөрсөн цэг нь дараах 5 үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Ландфилл;
- Хог хаягдлын талбай;
- Удирдлагын байгууламжууд;
- Зам, талбай;
- Бусад байгууламжууд.

Ландфилл байгууламж;

- a. 4-5 м гүн ухсан нүх;
- b. Шороон далан;
- c. Шүүрэл нэвчихээс хамгаалсан доторлогоо, үе давхаргууд;
- d. Шүүрлийг цуглуулах хуримтлуулах систем;
- e. Хог хаягдлын ялзралаас үүсэх хийг зайлуулах хоолой;
- f. Хог хаягдлын хучилтын хөрс нөөцлөх талбайтай;
- g. 2-р ээлжийн ландфилл талбай;
- h. 2-р ээлжийн шүүрүүлэх талбай.

Хог хаягдлын талбай;

- a. Энгийн хог хаягдлыг хүлээн авах, ангилан ялгах талбай;
- b. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, ангилан ялгах, хадгалах талбай;
- c. Агуулахын талбай (хог хаягдлын преслэх, дахивар нөөцийг түр хадгалах);
- d. Бордоожуулах талбай (Хүнсний хог хаягдал, малын өтөг бууц).

Удирдлагын байгууламжууд:

- a. Деспечрийн хяналт бүртгэлийн байр;
- b. Авто пүү;
- c. Ажилчдын байр (бие засах газар болон хувийн ариун цэвэр сахих шүршүүр);
- d. Дугуй ариутгах цэг талбай;
- e. Харуулын байр.


Зам, талбай:

- Авто зогсоол;
- Хүнд машин;
- Дотоод зам;
- Мөрөн-Хатгалын гол замаас хог хаягдлын цэг хүртэлх зам (сайжруулсан шороон);
- Ногоон байгууламжийн талбай.

Бусад байгууламжууд;

- Цахилгааны дэд станц;
- Үерийн хамгаалалтын далан шуудуу, хур борооны ус зайлуулах систем;
- Төмөр торон хашаа;
- Газрын доорх усны хяналт-шинжилгээний худаг;
- Хамгаалалтын бүс (300 м).

Ландфилл байгууламжийн ерөнхий бүтэц зохион байгуулалтын загварыг доорх зургуудаар үзүүлэв (Зураг 1-2).



Зураг 1. Ландфилл байгууламжийн ерөнхий бүтэц



Зураг 2. Хогийн давхарлан булах схем

Хатгал тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгууламжийн хүчин чадал нь 25000 м³ байхаар төлөвлөгдсөн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ландфилл байгууламжийн хүчин чадал

Он, үе шат	Хатгал	
	тонн-оор	м ³ -ээр
2021	654	1,090
2022	560	933
2023	545	909
2024	567	945
2025	537	895
1-р үе шат	2863	4772
2026	688	1,147
2027	824	1,374
2028	743	1,239
2029	1,001	1,430
2030	1,001	1,430
2-р үе шат	4,257	6,620
2031	1,008	1,440
2032	1,015	1,450
2033	1,023	1,461
2034	1,030	1,472
2035	966	1,380
3-р үе шат	5,042	7,203
2036	974	1,391
2037	981	1,401
2038	988	1,412
2039	996	1,423
Дүн	16,101	24,221
Шинээр тооцсон Ландфиллын хүчин чадал /м ³ /	25,000	
Ажлын даалгавар	40,000	
Зөрүү (+, -)	-15,000	

1.2. Төслийн бүтээн байгуулалт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНЫ ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ЛАНДФИЛЛ БОЛОН БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРЛОО¹

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, Хөвсгөл аймгийг байгалийн аялал жуулчлалын, Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэхээр зарласан билээ. Тус зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд БОАЖЯ-ны харьяа “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжиж байна.

2023 оны 11-р сарын 18-нд төслийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах” зорилтын хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Харганы амын ил задгай төвлөрсөн хогийн цэгийг нөхөн сэргээж, шинээр 2-р зэрэглэлийн төвлөрсөн хогийн цэг, ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг тус тус барьж ашиглалтад хүлээлгэн өгөв.

Тус байгууламж нь хог хаягдлаас хөрсөнд бохирдол нэвчихээс хамгаалсан геомембран доторлогоо, хог хаягдлаас ялгарах бохир шингэн болон метан хий зайлуулах хоолой бүхий ландфилийн 2 үүр, хог хаягдлаас ялгарах бохир шингэнийг цуглуулж ууршуулах сан, төвлөрсөн цэгт ирсэн хог хаягдлыг хэмжиж бүртгэх тусгай зориулалтын програм хангамж бүхий 40 тонны даацтай автопүү, боловсон 00, амралтын өрөө бүхий харуул бүртгэлийн байр, дахин боловсруулах боломжтой хаягдлыг нарийвчлан ангилан ялгах хатуу хучилттай талбай, сайжруулсан шороон зам, хог хаягдал салхиар тархахаас хамгаалсан хамгаалалтын торон хашаа, хог хаягдлыг тогтмол хучих зориулалттай шороо нөөцлөх талбай, төвлөрсөн цэгт ажиллах машин механизмын зогсоол, орон нутгаас гарах аюултай хог хаягдал түр хадгалах 20 тонны контейнер бүхий агуулах, шөнийн цагаар ландфиллын талбайг гэрэлтүүлэх цамхагт гэрэлтүүлэг, хяналтын камертайгаар тус тус төлөвлөгдсөн. Энэхүү бүтээн байгуулалтын зураг төслийг барилгын зураг төслийн “ЭН ЭЙ ПИ групп ХХК зохиож, манай компани хийж гүйцэтгэлээ.

(Автопүү) Хог хаягдлын тухай хуульд хоёрдугаар зэрэглэлийн төвлөрсөн хогийн цэг нь хог хаягдлыг хэмжиж бүртгэх хэрэгсэлтэй байхаар заасан байдаг. Уг шаардлагын дагуу Харганы амын хог хаягдлын төвлөрсөн байгууламжид 9 метрийн урттай 40 тонны даацтай автопүүг суурилуулахаар төлөвлөж, мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй Нью-Эталон ХХК, програм хангамжийн Линк энжайн ХХК-уудтай гэрээ байгуулан тус ажлыг гүйцэтгүүлснээр Хатгал тосгоны хог хаягдлыг хэмжиж бүртгэх боломжтой боллоо.

Бохир ус цэвэрлэх байгууламж) Түүнчлэн төслийн хүрээнд орон нутгийн эрс тэс уур амьсгал, хэт хүйтэн бүсийн нутаг дэвсгэрт тохиромжтой SBR (SEQUENCING BATCH REACTOR) буюу биологийн аргаар цэвэрлэх технологид суурилсан хоногт 75м3 хүртэл ахуйн бохир усыг хүлээн авч, цэвэрлэх хүчин чадалтай байгууламжийг барьж ашиглалтад хүлээлгэн өгч байна. Ахуйн бохир усыг биологийн аргаар 95-98 хувь хүртэл цэвэрлэх хүчин чадал бүхий тус цэвэрлэх байгууламж нь идэвхт лагийн процесст суурилсан агааржуулах болон холих процесс ээлжлэн явагдах бөгөөд тундасжих сав, SBR реактор, цэвэршүүлсэн усны танк, цуглуулах танк, лагийн танк, насос станц болон удирдлагын байртайгаар төлөвлөгдсөн.

¹ - <https://www.facebook.com/sustainabletourismdevelopmentproject> - БОАЖЯ

Энэхүү байгууламж ашиглалтад орсноор Хөвсгөл нуурийн эрэг дагуух 160 гаруй жуулчны баазууд, Хатгал тосгоны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарах ахуйн бохир усыг байгальд ил задгай асгаж, хөрс, усыг бохирдуулж байсан өнөөгийн нөхцөл байдлыг бүрэн зогсоох боломж бүрдэж байна.



Зураг 3. Нээлтийн ёслол, БОАЖЯ-ны сайд болон аймгуудын удирдлагууд оролцов.



Зураг 4. Одоогийн шинэ хогийн ландфилдах байгууламж, хуучин хогийн цэгийн зураг

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Хэмжилзүй” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Хатгал тосгоны хог хаягдлын байгууламж төслийн барилга угсралтын ажлын үеийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" болон 2021 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн боловсруулан БОАЖЯ-аар батлуулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төслийн барилга, газар шорооны ажлын үйл ажиллагаанаас агаарт үүсгэж буй тоосжилт, хөрсний элэгдэл, доройтол, ургамлан нөмрөгийн доройтол, хог хаягдлын нөлөөлөл, хатуу шингэн хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ. Мөн хуучин хогийн цэгийг бүрэн булшлах үйл ажиллагаа орох юм.

2023 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 109 565 260 (зуун ёсөн сая таван зуун жаран таван мянга хоёр зуун жаран) төгрөг төлөвлөсөн бөгөөд энэ хүрээнд төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан болно.

3. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн биелэлтийн тайлан хийхдээ 2021 онд батлагдсан төслийн БОННУ-ний тайлан, 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан хийж гүйцэтгэлээ. Дээр дурдснаар энэхүү төсөл нь өөрөө байгаль хамгаалах үйл ажиллагааны томоохон хэсэг болж байгаа юм. Өөрөөр хэлбэл хуучин Хатгал тосгоны Харганы аманд байрладаг хогийн цэг нь дараахь байгальд сөрөг нөлөөллийг үзүүлдэг байсан юм. Үүнд:

- Салхиар хог тархаж, тус амнаас эхлээд Хөвсгөл нуурын эрэг хүртэл өргөн нутгийг хамран тархаж байсан болно.
- Мөн тус уулын амнаас урсан үерийн болон зарим урсац нь хогтой холилдсон нөлөөгөөр Эгийн гол бохирдох эрсдэл үүсч байв.

Энэхүү байгальд ээлтэй төвлөрсөн хогийн цэгийн байгууламж байгуулагдснаар дээрх болон бусад олон бохирдол, эрсдлүүд байхгүй болж байгаа нь төслийн гол зорилгын биелэлт юм. Ийнхүү бид байгаль ээлтэй байгууламж байгуулж, мөн БОМТ-г хэрэгжүүлж ажилласан болно.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
---	----------------------------	---	--------------------------------------	-----------------------------------

1. Агаарын бохирдлоос хамгаалах чиглэлээр


1

Төслийн барилгын ажилд ашиглагдах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах


Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх

Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж ажилласан бөгөөд авто техникийн аюулгүй байдлыг байнга хангаж ажиллаж байна.

Зардлын хэмжээ: 1 050 000 төг



Жич: үлдсэн техникийн үзлэгийн баримт зургийг хавсралтаар оруулав.

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
2	Барилгын ажлын талбайгаас болон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайн тоосжилтыг дарах. Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, тоосжилт дарах өөр төрлийн бодис ашиглах, замыг дагтаршуулах	<p>Барилгын ажил эхлэх үед агаарын бохирдлоос сэргийлж тоосжилтыг бууруулах үүднээс барилгын ажлын талбайг байнга услаж байсан бөгөөд ялангуяа хуурайшилт ихтэй хаврын улиралд салхи ихтэй өдрийн цагуудад газар шорооны ажлыг түр зогсоох зэргээр агаар бохирдлоос сэргийлж ажилласан болно. Мөн барилгын ажлын явцад 7-р сард хийлгэсэн агаарын шинжилгээний дүн Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016-г хангаж байгааг гаргасан болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Автотээврээс үүдэлтэй бохирдол үүсэх нөхцлийг байнга хяналт тавин ажиллаж үзлэгт оруулахаас гадна өдөр тутмын хяналт байнга хийгдэж байсан болно. 2. Төслийн бүтээн байгуулалттай холбоотой техник болон үйл ажиллагаанаас хамаарсан тоосжилтыг үүсэхгүй байх тал дээр анхаарч ажилласан болно. 	

Тоосжилт дарж буй үеийн зураг

Агаарын бохирдлоос хамгаалах ажлын дүгнэлт


№	2. <u>Хөрс орчныг хамгаалах чиглэлээр</u>		
1	<p>Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө. Барилгын ажлын үед байнгын хөл хөдөлгөөнөөс хөрс, ургамлан бүрхэвч доройтож элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэнэ.</p>	<p>Барилгын ажил явагдах талбай болон материалын тээврийн замыг тэмдэгжүүлэх, аль болох бага талбай хамруулан хийж гүйцэтгэх</p>	<p>Барилгын ажлын талбайд замын болон аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг хангалттай хийж өгсөн бөгөөд зөвхөн нэг маршрутын замын дагуу тээвэрлэлт хийж байгаа болно.</p> <p>Жич: зурганд тэмдэгжүүлэлт болон дроноос зурганд замын чиглэлийг харуулав.</p> <p><u>Зардлын хэмжээ: 500 000</u> төг</p>
Нэмэлт ажлууд	<p>Хатгал тосгоны хатуу хог хаягдлын ландфилл байгууламж, шингэн хаягдлыг цэвэрлэх байгууламжын хашааг тойруулан гаргасан хамгаалалтын зурвасын арчилгааг 7 сарын 5-нд хийлээ.</p>		






3. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг багасгах				
1	Төслийн талбайн гадуур байгуулагдах үерийн усны суваг шуудуунд мал амьтан унаж эрсдэх	Төслийн талбайн гадуур байгуулагдах үерийн усны суваг шуудуу нь гадуураа мал амьтан унаж үхэхээргүй торон хашаатай байх шаардлагатай.	Төслийн хүрээнд мал амьтнаас хамгаалсан ангилан ялгах талбайн хашаа 25x20, шүүрлийн сангийн хашаа 20x25, зогсоолын тууз зэргийг байгуулан ажиллаж байна.	
2	Төслийн үйл ажиллагаанаас шувуудад үзүүлэх сөрөг нөлөөлөл	Хог хаягдлын төвлөрсөн цэгийн хашааны тал бүрд нь шувуу үргээгч төхөөрөмж суурилуулах шаардлагатай. Шувуудыг өндөр хүчдэлийн шон дээр суулгахгүй, үүр засуулахгүй байх зорилгоор шувуу үргээгч төхөөрөмжийг төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын шон бүр дээр стандартын дагуу суурилуулах шаардлагатай;	Төслийн талбайн эргэн тойронд шувуу үргээх төхөөрөмжийг суурилж байгаа болно. Төслийн бүтээн байгуулалттай холбоотойгоор гүйцэтгэл бүрэн хийгдэж байна. Энэд шувуу үргээгч тольтой болон тросстой 2 төрлийг ашиглаж байна. <i>Зардлын хэмжээ:</i> 1 000 000 төг	

4. <u>Усан орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах</u>			
1	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох.	Барилгын ажилд ус авч ашиглах гүний худгуудтай гэрээ байгуулж, усны төлбөр тооцоог холбогдох журмын дагуу хийх.	Алаг-Эрдэнэ сум болон Хатгал тосгоны удирдлагуудтай харилцан тохиролцон гэрээг байгуулж ажиллаж байгаа болно. <u>Зардлын хэмжээ: 1 000 000 төг</u>
Төлөвлөгөөнд зарцуулсан зардлын хэмжээ:			3 550 000

2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллах	Нийт 50 ш мод тарих	<p>Төслийн бүтээн байгуулалт төлөвлөгөөнд ногоон байгууламжын төлөвлөгөө тусгагдсан бөгөөд 2023 онд нийт 7 ширхэг нарс, 470 ширхэг хайлаас тарьсан.</p> <p>Хог хаягдлын ландфилл байгууламж, шингэн хаягдлыг цэвэрлэх байгууламжинын хашааг тойруулан гаргасан хамгаалалтын зурваст 500 ширхэг хайлаас мод, 8 ширхэг нарс мод нийт 508 ширхэг мод тарих ажлыг гүйцэтгэсэн бөгөөд ургалтын хувь 95%-тай байна.</p> <p><u>Туслан гүйцэтгэгч</u> : Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн сум дундын ойн анги Хавсралтаар бусад зургийг оруулав.</p>	

2	Хуучин хог хаягдлын цэгийг бүрэн нөхөн сэргээх	Нөхөн сэргээлтийг үргэлжлүүлэн хийх	Төслийн талбайн хуучин хогийн цэгийн нийт 9.2 га талбайг 4 удаагийн давтамжтайгаар түрж, хар хөрсөөр хучиж нөхөн сэргээлтийг хийж ажилласан байна.	  
---	--	-------------------------------------	--	--



Хатгал тосгоны хуучин хогийн цэгийн хог хаягдлыг түрэх, бөөгнүүлэх ажил



Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны шинэ төвлөрсөн хогийн цэгт мод тарих ажил/ 2023.06.04/





3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1		Хамгаалалтын хашаа барих	3 хиргисүүрийн эргэн тойруулан хашаа барих ажлыг хийж гүйцэтгэлээ.	
2	Түүх соёлын өвийн дурсгал	Таних тэмдэг байршуулах	3 хиргисүүд бүрд тэмдэгжүүлсэн болно.	
Төлөвлөгөөнд зарцуулсан зардал:			3 750 000 төг	



4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс хог хаягдлын төвлөрсөн цэг барих төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	www.tsag-agaar.mn, Хөвсгөл аймгийн УЦОШГ-н http://khuvsgul.tsag-agaar.gov.mn/ зэрэг сайтуудаас цаг агаарын урьдчилсан сэргийлэх мэдээллүүдийг байнга авч төслийн үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. Мөн гар утасны цаг агаарын мэдээлэлтэй холбоотой аппликейшнуудыг ашиглаж байна.	
2	Гал түймрийн улмаас төслийн үйл Ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Компаний ажилчдад ШУТИС-н ХШУС-н гамшгаас хамгаалах менежмент хичээлийн багш Ч.Даваасүрэн 2023 оны 8-р сарын 4-нд галын аюулгүй байдал, авах арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулсан болно. Мөн ажилчдад галын аюулгүй байдлыг анхааруулах сурталчилгааны самбарыг байрлуулан ажиллаж байна. Зардлын хэмжээ: 1 400 000 төг	

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
3		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг өдөр ажил эхлэхэд танилцуулан, гарын үсэн зуруулан ажиллаж байна.	
5	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Хөдөлмөр хамгааллын сургалтыг хариуцсан инженер нь тогтмол зохион байгуулж, гамшгаас хамгаалах сэргийлэх зөвлөмжийг боловсруулан ажиллаж байна. Зардлын хэмжээ: 500 000 төг	
6		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хувцсаар байнга хангагдан ажиллаж байна.	

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
8		Барилгын ажилчдын түр суурин бүрийг анхны тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай хэрэгслүүдээр хангах	<p>Анхны тусламжийг хэрэгслийг болзошгүй бэлэн байдалд бэлтгэн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Анхны тусламжийн хэрэгслүүдийг бэлтгэсэн болно.</p> <p>Зардлын хэмжээ: 1 000 000 төг</p>	
9	Ажилчдын хотхоныг зөв зохион байгуулаагүйн улмаас ажилчдын эрүүл мэндэд эрсдэл үүсэх	Бие засах өрөө, бусад ариун цэврийн байгууламжыг сар бүр ариутгаж ажиллах	<p>Зориулалтын стандарт хангасан бие засах газар болон гар угаах цэгийг сар бүр ариутган ажиллаж байна.</p> <p>Зардлын хэмжээ: 1 720 000 төг</p>	
Зарцуулсан зардал:			4,620,000 төгрөг	

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Ажилчдын хотхон, барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд	Энэхүү төлөвлөгөөний хүрээнд хуучин Хатгал тосгоны ашиглаж байсан хогийн цэгийг түрж овоолох, хамгаалалтын ногоон хашаан зурвас татах, түрж булах ажлуудыг 2023 онд хийж гүйцэтгэсэн болно.	 <p data-bbox="1659 671 2085 695">Ангилан ялгах хогийн савны зураг</p>
2	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд		 <p data-bbox="1615 1011 2092 1067">Хуучин хогийн цэгийг нөхөн сэргээсэн байдал</p>

3	<p>Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх, стандартын дагуу хадгалах, нийлүүлэгч талд буцаан өгөх, сав баглаа боодлын хор аюулыг саармагжуулах эсхүл нийлүүлэгч талд буцаан өгөх арга хэмжээнүүдийг тодорхойлох</p>	<p>Барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд</p>
	<p>Зардлын хэмжээ</p>	<p>5 100 000</p>



Барилгын хогийг ангилан ялгаж буй үеийн зураг

Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Тус компанийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.



Зураг.3. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим


хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор дараах дотоод журмуудыг даган мөрддөг.

1. Хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам
2. Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах журам

Хог хаягдлыг зайлуулах, устгах арга зам

Хог хаягдлын ангилан ялгалт


Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор өнгөөр кодчилсон ба хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүд дээр байрлуулж ашигладаг (Зураг.4).



Зураг.4. Ажилчдын хотхоноос гарах хаягдлын ангилалт


6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР



Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Гүйцэтэсэн ажил	Баталгаажуулах баримт, фото зураг
Агаар орчны хэмжилт шинжилгээ	Төслийн талбайд 4 байршилд	Хөрсний дээжлэлтийг 2023 оны БОМТ-д тусгасны дагуу нийт 4 цэгүүдээс авч, магадлан итгэмжлэгдсэн “Инженер Геодези” ХХК -ний төв лабораторид шинжилгээнд өгсөн байгаа юм.	
Хөрсний орчны хэмжилт шинжилгээ	Төслийн талбайд 4 байршилд	Агаарын хэмжилт судалгаанд агаарын тоосжилт хэмжигч Particle counter болон Dust track багажуудыг ашигласан болно. Мөн агаарын бусад хийн хэмжилт судалгаа Хөвсгөл аймгийн УЦУОШГ-н БОШЛ-н эрхлэгч Д.Баасанцэрэн, техникч Т.Мөнхцэцэг нар хийж гүйцэтгэсэн болно.	 

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Гүйцэтэсэн ажил	Баталгаажуулах баримт, фото зураг
Ургамлын мониторинг	Төслийн талбайд 4 байршилд	Ургамлын бичиглэлийг торын аргаар хийж гүйцэтгэсэн болно. Тухайн арга нь 1 м x 1 м хэмжээтэй квадрат тор дотор байгаа ургамлын бүрхэвчийн байдал, ургамлын өндөр, тоо зэргийн бичиглэлийг хийнэ.	
Бусад шинжилгээ	Төслийн талбайд 4 байршилд	Мөн хээрийн судалгааны явцад төслийн талбайгаас цацрагийн тунгийн чадлыг дозиметрээр тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэлээ.	
Зарцуулсан зардлын хэмжээ:		6 545 260 төгрөг	Хавсралтаар дээж авах цэгүүдийн зургийг оруулав.

Жич: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага болон мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулан хэрэгжүүлүүлсэн болно.

7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны захиргаатай хамтран төсөлд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх, тэднээс ажлын шаардлага хангасан иргэдийг ажлын байраар хангах	Хатгал тосгоны иргэд	Тухайн сумын болон тосгоны иргэдээс 20-30 хүнийг байнгын болон түр ажлын байраар ханган, модны усалгааг тогтмол хийлгэн ажлуулж байна.	

2	Сум, баг, тосгоны удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Төслийн явцыг орон нутгийн удирдлагуудад танилцуулах	<ul style="list-style-type: none">- 2023 оны 4-р сарын 22 өдөр БОАЖЯ-ны сайд төслийн талбайд ажилтай танилцаж ажилласан болно.- Хөвсгөл аймгийн Хатгал тосгон: Ландфилл байгууламжийн далан болон үүрийн нягтралын хяналтыг 2023 оны 5-р сарын 13-нд хийсэн болно.	 
---	--	--	---	--

- Төслийн дэд зохицуулагч Г.Дэлгэрмаагаар ахлуулсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн баг болон аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ – ын дарга Б.Оюунтуяа даргаар ахлуулсан ажлын хэсэг төслийн талбайн гүйцэтгэлтэй 2023 оны 6 сарын 14 өдөр танилцаж байна.
- Барилга угсралтын ажил дууссантай холбоотойгоор БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны А/356 дугаар тушаалаар байгуулагдсан урьдчилсан үзлэг хийх техникийн комисс Хатгал тосгоны хатуу хог хаягдлын байгууламж, бохир ус цэвэрлэх байгууламжид 2023 оны 10-р сарын 23-ны өдөр ажиллаж гүйцэтэгч болон бусад холбогдох байгууллагуудад 44 нэр төрлийн хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмжийг өгсөн болно.



3	<p>“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулахад бэлэн болгох</p>	<p>Төслийн талбайд хамрах</p>	<p>Төслийн 2023 оны БОМТ-ны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх асуудал дээр мэргэжлийн Глобал Энвайрон ХХК-тай гэрээ байгуулан зөвлөхөөр ажиллуулж байна.</p> <p>Зардлын хэмжээ: 8 000 000 төг</p>	<p>Хавсралтаар гэрээний баталгаажуулсан хэсгийг оруулав.</p>
			<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр БОАЖЯ-наас хэрэгжүүлж буй " L3787/3788-MON: Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл"-ийн зөвлөх болон гүйцэтгэгч компанийн ажилтан, албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулав.</p> <p>Сургалт хоёр үндсэн зорилгын дор зохион байгуулагдав.</p> <p>1.Төслийн хэрэгжилтийн явцад үүсдэг санхүүгийн болон худалдан авалт, гэрээний биелэлттэй холбоотой нийтлэг асуудлаар зөвлөмж, зааварчилгаа өгөх,</p> <p>2. Төсөлд байгаль орчин, нийгмийн асуудлаар Азийн Хөгжлийн Банк болон Монгол Улсын Засгийн газраас тавигддаг шаардлагууд (байгаль орчны үнэлгээ, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө), барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион</p>	

байгуулах, Эрүүл Ахуй Хөдөлмөрийн Аюулгүй Байдал (ЭАХАБ)-ыг Төсөл Хэрэгжүүлэх Нэгж (ТХН), зөвлөх болон гүйцэтгэгч байгууллагуудын ажилтан албан хаагчдад танилцуулах,
Тус сургалтаар
Ø Төслийн хяналт, шинжилгээ-үнэлгээний шалгуурууд,
Ø Төслийн 2023-2024 ажлын төлөвлөгөө,
Ø Санхүүгийн тайлан, баримт бүрдүүлэлтэд тавигдах шаардлага,
Ø Худалдан авалт, гэрээний биелэлтэд тавигдах шаардлага,
Ø Азийн хөгжлийн банкны Хамгааллын бодлого (2009 он), түүнд тавигдах шаардлагууд:
Ø Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, журам тавигдах шаардлагууд,
Ø АХБ-ны жендэр, хөгжлийн бодлого,
Ø Төслийн нийгэм, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт,
Ø Дэд бүтцийн бүтээн байгуулалтын явц дахь Эрүүл Ахуй Хөдөлмөрийн Аюулгүй Байдал (ЭАХАБ),
Ø Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, тулгарч буй асуудал зэрэг сэдвүүдээр танилцуулга хийсэн.
Төслийн зохицуулагч П.Түвшинжаргал төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудыг хугацаанд нь ашиглалтад оруулах, байгаль орчны хамгааллын өнөөгийн нөхцөлд дүн шинжилгээ хийж ажиллах тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгов.



			Сургалтад: АХБ, Төслийн Хэрэгжүүлэх Нэгж (ТХН) , Барилгын хөгжлийн төв, “Эн Эй Пи Групп” ХХК, “Хаанзаа сервис” ХХК, “Бээжин Юни Констракшн Групп ” ХХК, “Хэмжилзүй” ХХК, “Мандалт Констракшн” ХХК, “Мөнх харилцаа”ТББ, Эс Ар Пи инженеринг Монголиа ХХК зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцов.	
	Зарцуулсан зардлын хэмжээ:		10 000 000 төгрөг	

7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
1	2023 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг Хөвсгөл аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн үр дүнг тодорхой тусгаж, фото зургаар баримтжуулсан байх	БОМТ-ний биелэлтийн үр дүнг тухай бүр нь Азийн хөгжлийн банкны Тогтвортой аялал жуулчлал төсөлд нэгжид байнга тайлагнаж явсан болно. Мөн биелэлтийн цахим хэлбэрээр илгээсэн болно.	

8. 2023 ОНЫ БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГДСЭН ДҮН

Төслийн 2023 оны БОМТ-ны хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-аар батлагдсан төлөвлөгөөний хүрээнд бичиж тайлагнасан болно.

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	ТАЙЛБАР
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	3 550 000	
ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	70 000 000	Төслийн бүтээн байгуулалт төлөвлөгөөнд ногоон байгууламжын төлөвлөгөө тусгагдсан бөгөөд 2023 онд нийт 7 ширхэг нарс, 470 ширхэг хайлаас тарьсан.
ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	3 750 000	
ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4 620 000	
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	5 100 000	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	6 545 260	
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	10 500 000	
ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	4 500 000	
2023 ОНЫ БОМТ-НЫ ХЭРЭГЖИЛТЭНД ЗАРЦУУЛСАН ДҮН		109 565 260

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

1. Шинжилгээний дүн – Хөрсний хүнд элементийн шинжилгээний дүн -2023
2. Шинжилгээний дүн –Агаарын шинжилгээний дүн, 2023
3. Шинжилгээний дүн –Цацрагийн шинжилгээний дүн, 2023
4. Шинжилгээ авсан цэгүүдийн байрлал
5. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө, зөвлөмж
6. Бусад холбогдох зураг, баримтууд

Ашигласан материалын жагсаалт

- БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А-618 тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- Шинжилгээний дүнгүүд

ХАВСРАЛТ -1. ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН



ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Дугаар: 23/2866

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@g-mongol.mn

Дэж авсан огноо: 2023 он 07 сарын 18

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 07 сарын 19-20

Дэж авсан газрын нэр: Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон, “Хэмжилзүй” ХХК-ны Хатгал тосгон хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төсөл

Координат: 50°23'08.67" 100°06'12.61"

Дэж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Хэмжилзүй” ХХК

Харилцах утас: 99998517

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдэж и сууриул мг-эжв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	22/5863	Дэж-1	0-15	8.30	0.07	0.164	1.26	5.44	8.0	2.2	1.4	8

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	22/5863	Дэж-1	0-15	18.4	53.7	16.2	3.4	5.3	3.1	11.8

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	22/5863	Дэж-1	0-15	31.1	0.02	32.2	11.7	51.9	17.1
				Хүлцэх агууламж /MNS 5850:2019/					
				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
				Хорттой агууламж /MNS 5850:2019/					
				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
				Аюултай агууламж /MNS 5850:2019/					
				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
				Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт					
				/MNS 5850:2019/					

*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний харуу нь тухайн үзэгийн дээжэнд хамаарах ба хуульчлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч: Л.Цагаандархи /MS.c/ -
Задлан шинжээч: О.Дагвийжалал /MS.c/



ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Дугаар: 23/2872

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@g-mongol.mn

Дэж авсан огноо: 2023 он 07 сарын 18

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 07 сарын 19-20

Дэж авсан газрын нэр: Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон, “Хэмжилзүй” ХХК-ны Хатгал тосгон хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төсөл

Координат: 50°23'11.51" 100°06'19.63"

Дэж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Хэмжилзүй” ХХК

Харилцах утас: 99998517

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдэж и сууриул мг-эжв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	22/5866	Дэж-1	0-15	8.36	0.12	0.277	5.62	1.28	24.1	5.6	3.1	26

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	22/5866	Дэж-1	0-15	13.2	40.1	30.0	3.6	9.0	4.1	16.7

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	22/5866	Дэж-1	0-15	35.4	0.01	27.3	19.4	60.8	30.2
				Хүлцэх агууламж /MNS 5850:2019/					
				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
				Хорттой агууламж /MNS 5850:2019/					
				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
				Аюултай агууламж /MNS 5850:2019/					
				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
				Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт					
				/MNS 5850:2019/					

*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний харуу нь тухайн үзэгийн дээжэнд хамаарах ба хуульчлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч: Л.Цагаандархи /MS.c/ -
Задлан шинжээч: О.Дагвийжалал /MS.c/

ХАВСРАЛТ -2. АГААР БОЛОН ЦАЦРАГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГҮҮД

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bshztl@gmail.com

БАЙГАЛЬ
Орчин амьжирсан төв лаборатори

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/A-150
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Хэмжилзүй” ХХК
